



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/93

Сүхбаатар сум


Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."н", 29.1.6."а", "в", 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5² дугаар зүйлийн 5².1, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, 16.2.10, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 28 дугаар зүйлийн 28.1.7, 28.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал хайх, ашиглах, бичил уурхайн чиглэлээр явуулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор "Уул уурхайн зориулалт бүхий тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.


2. Журмын хэрэгжилтийг хангаж, аймгийн нутаг дэвсгэрт нэвтэрсэн болон дайран өнгөрч буй уул уурхайн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэлжүүлэх ажлыг хариуцан, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль эрчин, аялал жуулчлалын газар, сумдын Засаг дарга нартай хамтран зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 03 дугаар сарын 18 -ний
өдрийн А/33 дугаар захирамжийн
хавсралт



Уул уурхайн зориулалт бүхий тээврийн
хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал хайх, ашиглах, бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын уул, уурхайн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор нэвтэрч буй болон дайран өнгөрч буй уул уурхайн /тусгай/ зориулалтын тээврийн хэрэгсэл /цаашид “технологийн тээврийн хэрэгсэл” гэх/-ийн хөдөлгөөнд хяналт тавих, бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход оршино.

1.2. Энэ журмыг аймаг дахь Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газрын алба хаагчид, ажилтан болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор байгуулагдсан ажлын хэсэг, замын постуудад гарч буй Байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нар өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана

Хоёр. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих

2.1. Цагдаагийн алба хаагч нь олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто зам, хяналтын цэгүүдэд хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр үүрэг гүйцэтгэхдээ Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалаар батлагдсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам” болон энэхүү журам, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн, аймаг /сумдын/-ийн нутаг дэвсгэр, байнгын, түр постуудаар нэвтэрч буй болон дайран өнгөрч байгаа дараах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавина. Үүнд:

- 2.1.1. технологийн тээврийн хэрэгсэл;
- 2.1.2. технологийн тээврийн хэрэгслийг ачсан, чирсэн тээврийн хэрэгсэл;
- 2.1.3. уул уурхайн эрдэс, бодис олборлоход ашигладаг техник, хэрэгсэл, тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл;
- 2.1.4. тэсэрч, дэлбэрэх бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл;

2.1.5. Бичил уурхайн зориулалтаар нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч хуулийн этгээд нь ашигт малтмал олборлохдоо 3500см³ хүртэлх багтаамжтай, дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизм зэргийг нэр, хаягтай бүртгэх

2.2. Мэргэжлийн хяналтын Улсын байцаагч нь Цагдаагийн алба хаагчаас гудамж, замд хяналт шалгалтаар үүрэг гүйцэтгэх явцад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, олж тогтоох ажилд шаардагдах мэргэжил, арга зүйн болон техник хэрэгслийн туслалцаа, дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

2.3. Мэргэжлийн хяналтын Улсын байцаагч, Цагдаагийн алба хаагчид хяналт шалгалтын явцад хяналтын цэгээр аймгийн нутаг дэвсгэрт нэвтэрсэн, дайран өнгөрсөн, буцаасан техник, тоног төхөөрөмжийн бүртгэлийг цаг тухайд нь үнэн зөв хөтлөх, шаардлагатай тохиолдолд албадан буцаах ажлыг зохион байгуулж, мэдээллийг аймгийн Засаг дарга, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлд хүргүүлж, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

Гурав.Бусад

3.1. Журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтан, алба хаагчид Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл ногдуулна.